

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/71/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn
Аудитор С.Шийлэгмаа
Утас: 261628 Цахим хаяг: shiilegmaas@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Солид Юнити Аудит ХХК-ийн
захирал Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаяг.аар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	1
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	2
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	6
АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ХАЦЭХ	Худалдан авсан цахилгаан эрчим хүч
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ К.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

2026.03.16 № 06/643
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон 8,672.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дахин үнэлгээний нэмэгдлийн дүн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 6,358.9 сая төгрөгөөр зөрүүтэй, НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ийн "Үндсэн хөрөнгийн зүйлтэй холбоотойгоор өмчид тусгагдсан дахин үнэлгээний нэмэгдлийг тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед хуримтлагдсан ашиг дансанд шилжүүлж бүртгэнэ" гэсэн заалтын дагуу бүртгэж тайлагнаагүй;
- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хойшлогдсон орлогын үлдэгдэл, хүлээн зөвшөөрөлтийг уг орлоготой холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн элэгдэл, үлдэх өртөгтэй уялдуулан НББОУС 20 "Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба засгийн газрын туслалцааны тодруулга"-ын 17 дугаар параграфын дагуу бүртгээгүйгээс 352.2 сая төгрөгийн зөрүүтэй;

- Тайланд онд хуримтлагдсан ашиг, алдагдал дансанд өмнөх жилийн нягтлан бодох бүртгэлийн алдаатай холбоотой өмнөх тайлант жилд орлого, зардлаар бүртгэх 4,312.5 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэснээс үүсэх үр нөлөө нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.6, 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.6 дах заалттай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгаан эрчим хүчний алдагдлыг 11.7 хувиар баталсныг тайлант онд компани 9.7 хувьд хүргэн 2.03 хувиар бууруулснаар бүрдүүлсэн 21,666.7 сая төгрөгийн орлогыг тарифт тусгуулан ухаалаг тоолуурын нэгдсэн системийг нэвтрүүлэх төслийн II дахь шатыг хэрэгжүүлсэн байна. Төслийн хүрээнд Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Зуслангийн хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд болон Налайх, Зуунмод төвийн хэрэглэгчдэд нийт 129,019 ширхэг ухаалаг тоолуурыг суурилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтаар агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэлийн болон аймгийн төв, зарим сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлэхээр баталсны дагуу 2025 онд гэр хорооллын айл өрхийн хэрэглэгчдэд 51,435.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг, Засгийн газрын “Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2018 оны 324 дүгээр тогтоолын дагуу тайлант онд 173.4 сая төгрөгийн чөлөөлөлтийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлсэн байна.

Цахилгаан эрчим хүчний алдагдлыг төлөвлөснөөс 2.03 хувиар бууруулж, борлуулсан цахилгаан эрчим хүч 151.1 сая кВтц буюу 4 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Тайланд онд хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын ажлын хүрээнд 40,338.59 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэснээс 25,048.85 сая төгрөг нь Ухаалаг тоолуур төслийн хөрөнгө байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,342,127,439.71	6,162,778,452.08
1.1.2	Дансны авлага	54,336,663,365.74	86,026,787,729.92
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,772,907,632.41	7,895,975,496.18
1.1.4	Бусад авлага	1,309,294,519.84	890,587,628.81
1.1.6	Бараа материал	13,495,382,378.49	23,621,434,263.21
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	27,329,397.64	133,688,081.92
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	78,283,704,733.83	124,731,251,652.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	360,494,468,619.76	420,537,992,262.74
1.2.2	Биет бус хөрөнгө	4,605,921,923.16	5,392,931,299.70
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	317,862,309.13	202,276,114.92
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	365,418,252,852.05	426,133,199,677.36
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	443,701,957,585.88	550,864,451,329.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	57,000,841,282.11	109,212,239,421.54
2.1.1.2	Цалингийн өглөг	7,183,085,397.71	8,283,635,959.77
2.1.1.3	Татварын өр	5,581,279,085.95	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	14,002,154.45	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	2,354,388,007.27	2,354,388,007.27
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,026,632,752.43	2,712,277,098.43
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	454,123,200.95	5,920,283,074.12
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	74,614,351,880.87	128,482,823,561.13
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	19,099,490,712.89	16,745,102,705.62
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,066,231,619.48	12,369,756,771.80
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	45,858,386,731.17	88,359,075,200.15
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	70,024,109,063.54	117,473,934,677.57
2.2	Өр төлбөрийн нийт дүн	144,638,460,944.41	245,956,758,238.70
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	247,079,143,164.82	250,878,703,795.63
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	40,064,941,872.37	39,501,278,757.19
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,572,308,536.48	10,368,527,883.38
2.3.9	Хуримтлагдсан ашиг	5,347,103,067.80	4,159,182,654.58
2.3.11	Эздийн өмчийн дүн	299,063,496,641.47	304,907,693,090.78
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	443,701,957,585.88	550,864,451,329.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024	2025
1	Борлуулалтын орлого (цэвэр)	844,168,466,635.46	1,162,896,046,673.60
	ЦЭХ-ний орлого	721,348,935,008.18	1,037,683,993,673.60
	Түгээх үйлчилгээний орлого	122,819,531,627.28	125,212,053,000.00
2	Борлуулалтын өртөг	780,137,887,867.21	1,092,106,599,328.08
	ХАЦЭХ	708,594,520,743.63	1,010,759,507,021.08
	Түгээх үйл ажиллагааны зардал	71,543,367,123.58	81,347,092,307.00
3	Нийт ашиг (алдагдал)	64,030,578,768.25	70,789,447,345.52
4	Түрээсийн орлого	120,772,836.36	136,462,840.91
5	Хүүгийн орлого	1,411,614,077.65	2,637,398,373.57
8	Бусад орлого	21,557,378,146.09	25,946,769,998.05
9	Борлуулалт, маркетингийн зардал	45,736,125,068.96	51,437,853,385.69
10	Ерөнхий ба удирдлагын зардал	20,971,597,110.88	26,954,448,513.96
11	Санхүүгийн зардал	370,596,741.62	328,978,497.83
12	Бусад зардал	18,249,925,089.60	17,705,050,605.67
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	24,159,973.64	49,923,109.08
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,816,259,790.93	3,133,670,663.98
19	Орлогын татварын зардал	552,632,491.44	2,389,029,386.65
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,263,627,299.49	744,641,277.33

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	239,360,638,644.76	40,954,606,964.40	10,209,210,443.49	3,238,587,459.88	293,763,043,512.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	847,516,635.80	847,516,635.80
3	Залруулсан үлдэгдэл	239,360,638,644.76	40,954,606,964.40	10,209,210,443.49	4,086,104,095.68	294,610,560,148.33
4	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	1,263,627,299.49	1,263,627,299.49
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	7,718,504,520.06	-	(3,636,901,907.01)	-	4,081,602,613.05
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(2,628,327.37)	(2,628,327.37)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(889,665,092.03)	-	-	(889,665,092.03)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	247,079,143,164.82	40,064,941,872.37	6,572,308,536.48	5,347,103,067.80	299,063,496,641.47
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(2,496,224,805.73)	(2,496,224,805.73)
11	Залруулсан үлдэгдэл	247,079,143,164.82	40,064,941,872.37	6,572,308,536.48	2,850,878,262.07	296,567,271,835.74
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	744,641,277.33	744,641,277.33
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	3,799,560,630.81	-	3,796,219,346.90	-	7,595,779,977.71
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(563,663,115.18)	-	563,663,115.18	-
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,878,703,795.63	39,501,278,757.19	10,368,527,883.38	4,159,182,654.58	304,907,693,090.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	955,161,424,664.03	1,317,797,483,371.3
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	737,751,666,924.64	1,011,678,030,168.20
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	321,583,534.00	324,739,598.00
	Татаас, санхүүжилтийн орлого	148,399,362,217.47	192,854,089,378.07
	Бусад мөнгөн орлого	68,688,811,987.92	112,940,624,227.12
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	941,209,216,320.77	1,303,463,423,497.6
	Ажиллагчдад төлсөн	64,033,757,719.36	76,446,705,244.41
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,313,702,786.19	24,169,399,235.86
	Бараа материал худалдан авахад төлсөн	33,363,828,074.88	49,388,806,063.90
	Ашиглалтын зардалд төлсөн	2,681,237,831.42	2,846,240,756.65
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,153,226,356.12	3,137,838,765.64
	Хүүгийн төлбөрт төлсөн	462,913,729.01	421,792,636.31
	Татварын байгууллагад төлсөн	13,934,720,254.20	29,659,724,935.59
	Даатгалын төлбөрт төлсөн	115,995,943.00	512,643,561.45
	Бусад мөнгөн зарлага	803,149,833,626.59	1,116,880,272,297.86
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,952,208,343.26	14,334,059,873.72
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	702,127,587.83	2,165,455,414.16
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	23,878,973.64	49,923,109.08
	Хүлээн авсан хүүгийн орлого	678,248,614.19	2,115,532,305.08
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,936,191,744.45	15,323,592,110.62
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,936,191,744.45	15,323,592,110.62
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,234,064,156.62)	(13,158,136,696.46)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,357,992,717.90	2,355,272,164.89
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,355,364,390.53	2,355,272,164.89
	Төлсөн ногдол ашиг	2,628,327.37	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,357,992,717.90)	(2,355,272,164.89)
4	Валютын ханшийн зөрүү		-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,360,151,468.74	(1,179,348,987.63)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,981,975,970.97	7,342,127,439.71
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,342,127,439.71	6,162,778,452.08

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган,төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биетээр	Хувиар
	А	1	2	3	4	5=4-3	6=4/3
1	Худалдан авах цахилгаан	мян.кВтц	4,044,572.3	4,230,689.8	4,303,068.4	72,378.6	102%
	ЦЭХ-ний алдагдал					-	
	хувиар	хувь	10.54%	11.75%	9.72%	-2.03%	83%
	биетээр	мян.кВтц	426,407.3	497,031.1	418,266.3	(78,764.8)	84%
	Борлуулах ЦЭХ	мян.кВтц	3,618,165.0	3,733,658.7	3,884,802.1	151,143.4	104%
2	Нийт орлого	мян.төг	867,282,394.7	1,134,480,242.8	1,191,666,601.0	57,186,358.2	105%
	ЦЭХ-ийн орлого, түрээс	мян.төг	721,348,935.0	967,480,175.8	1,037,683,993.6	70,203,817.8	107%
	Түгээх үйл ажиллагааны орлого	мян.төг	122,819,531.6	148,678,800.0	125,212,053.0	(23,466,747.0)	84%
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	мян.төг	23,113,928.1	18,321,267.0	28,770,554.3	10,449,287.3	157%
3	Нийт зардал, үүнээс	мян.төг	865,466,131.8	1,132,994,344.4	1,188,532,930.3	55,538,585.9	105%
	ЦЭХ-ийн төлбөр	мян.төг	138,621,686.0	156,945,832.1	160,068,372.7	3,122,540.6	102%
	Үйл ажиллагааны зардал	мян.төг	708,594,520.7	957,828,172.7	1,010,759,507.0	52,931,334.3	106%
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	мян.төг	18,249,925.1	18,220,339.6	17,705,050.6	(515,289.0)	97%
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг	-	26,582,600.0	29,219,965.0	2,637,365.0	110%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	1,816,262.9	1,485,898.4	3,133,670.7	1,647,772.3	211%
5	Орлогын татвар	мян.төг	552,632.5	148,589.8	2,389,029.4	2,240,439.6	1608%
6	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	1,263,630.4	1,337,308.6	744,641.3	(592,667.3)	56%
7	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал		1.0	1.0	1.0	(0.0)	100%
8	Нийт авлага	мян.төг	57,418,865.6	56,957,900.0	94,899,690.7	37,941,790.7	167%
	ЦЭХ-ийн авлага	мян.төг	54,336,663.4	53,741,100.0	86,026,787.7	32,285,687.7	160%
	Бусад авлага	мян.төг	3,082,202.2	3,216,800.0	8,872,903.0	5,656,103.0	276%
9	Нийт өр төлбөр	мян.төг	144,638,461.0	147,456,800.0	245,956,758.3	98,499,958.3	167%
	Богино хугацаат өр	мян.төг	70,024,109.1	92,026,500.0	96,697,661.7	4,671,161.7	105%
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	74,614,351.9	55,430,300.0	149,259,096.6	93,828,796.6	269%
10	Ажиллагсдын тоо	хүн	1,950.0	1,953.0	1,953.0	-	100%
11	Цалингийн сан	мян.төг	68,539,188.7	83,165,159.9	82,863,448.3	(301,711.6)	100%
12	Цахилгаан тасалдан дундаж хугацаа Исайди	минут	900.3	1,128.6	1,037.6	(91.0)	92%
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	24,220,490.2	67,169,308.4	65,655,210.9	(1,514,097.5)	98%
14	Ухаалаг тоолуур	мян.төг	6,766,633.5	36,000,000.0	34,691,379.3	(1,308,620.7)	96%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 1932 онд байгуулагдсан, чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан салбартаа тэргүүлэгч компани болох эрхэм зорилготой бөгөөд Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон цахилгаан эрчим хүч түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд нийслэлийн 8 дүүрэг, Төв аймгийн 16 сумын 501 мянга орчим хэрэглэгч буюу Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувийг 0,4-35 кВ-ын хүчдэлийн түвшинд өөрийн эзэмшлийн шугам, дэд өртөөгөөр дамжуулан цахилгаан эрчим хүчийг түгээж, хангах үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний сүлжээний худалдан авсан цахилгаан эрчим хүчний 50 орчим хувийн түгээлт, борлуулалтыг хийж гүйцэтгэдэг ууган компаниудын нэг юм.

Тус компани алсын хараагаа “Найдвартай ажиллагааг хангасан үйлчилгээгээр манлайлагч, технологиор тэргүүлэгч, дэлхийн жишигт хүрсэн компани болно” гэж тодорхойлсон.

Компани үйл ажиллагаагаа явуулахдаа дараах тусгай зөвшөөрлийг ашигладаг байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч түгээх;
- Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах;
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл хийх;
- Цахилгааны шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт тохируулга хийх;
- Цахилгаан эрчим хүчний нэг ба гурван фазын механик, электрон, импульсын тоолуур, гүйдлийн трансформатор засварлах, худалдах, суурилуулах;
- Хуваарилах байгууламж, дэд станц, шугам тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээний монтёрын мэргэжил олгох, инженер техникийн ажилтны мэргэжил дээшлүүлэх, давтан сургалт явуулах.

Тус компани 100.0 хувь төрийн өмчит бөгөөд 66.0 хувийг Эрчим хүчний яам, 34.0 хувийг Эрчист Монгол ТӨХХК эзэмшдэг байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Тус компани үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажилладаг байна.

Тайлант онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 17 удаа хуралдаж, 34 тогтоол гарсан байна. Үүнд:

- Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр тогтоолоор, Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг 02 дугаар тогтоолоор дэмжихээр шийдвэрлэсэн;
- Компанийн зохион байгуулалтын бүтэц орон тооны дээд хязгаарт 2025 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулан 1953 орон тоогоор баталсан,
- Компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 21, 9 дүгээр сарын 15-ны өдрийн 28, 11 дүгээр сарын 03-ны өдрийн 32 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авах, балансаас балансад шилжүүлэх, хөрөнгө акталж данснаас хасах саналыг дэмжих асуудлыг 2025 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 23,24,25,26 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлэсэн;
- Компанийн 2026 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний төслийг дэмжих 34 дүгээр тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр гаргасан байна.

Компанийн хувьцаа эзэмшигчид 2025 онд 4 удаа хуралдаж, 12 тогтоол гарсан бөгөөд ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталж, 2024 оны үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй байх асуудлыг 04 дүгээр тогтоолоор, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, өмчийг нэмэгдүүлэхийг 6 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Зөрчлийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам;
- Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм (Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт);
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоолын хавсралт)

2025 онд авч хэрэгжүүлсэн онцлох ажлууд:

- Ухаалаг тоолуурын нэгдсэн системийг нэвтрүүлэх төслийн II дахь шатны ажлын хүрээнд Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Зуслан хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд болон Налайх, Зуунмод төвийн нийт 129019 хэрэглэгчид ухаалаг тоолуурыг суурилуулсан;
- Түгээх үйл ажиллагааны чиглэлээр нийт 23.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр 6,484 нэр төрлийн их засвар, ТЗБАХ болон хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэсэн;
- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Зуслангийн бүсийн 31892 хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор 35/10 кВ-ын Хадат дэд станцын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн;
- Хүлээгдэж буй гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний алдагдлыг 9.7 хувьд хүргэж, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр бууруулсан;
- Шуурхай ажиллагааг хангах зорилгоор суудлын 11, туулах чадвар сайтай 1, олон хүний багтаамжтай микробус 1, универсал трактор 2, авто кран 1-ийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авч, парк шинэчлэлт хийсэн байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн боловч Дотоод аудитын албаны 2025 оны төлөвлөгөөт аудитыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасан "Төслийн нэгжийн үйл ажиллагаа болон хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд ухаалаг тоолуур суурилуулах ажлын явц, гүйцэтгэлд орох" тайлантай танилцсан.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлэн боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/333 дугаар тушаалаар баталж, 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч бараа материалын хасагдуулаг тооцох аргачлалыг НББОУС 2 “Бараа материал”-т нийцүүлэн шинэчлэх, цахилгаан эрчим хүч хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, зохицуулалтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 107,162.5 сая төгрөгөөр буюу 24.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,342.1	6,162.8	(1,179.3)
Авлага	57,418.9	94,813.4	37,394.5
Бараа материал	13,495.4	23,621.4	10,126.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	27.3	133.7	106.4
Үндсэн хөрөнгө	360,494.5	420,538.0	60,043.5
Биет бус хөрөнгө	4,605.9	5,392.9	787.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	317.9	202.3	(115.6)
Нийт хөрөнгө	443,702.0	550,864.5	107,162.5
Өр төлбөр	144,638.5	245,956.8	101,318.3
Эздийн өмч	299,063.5	304,907.7	5,844.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	443,702.0	550,864.5	107,162.5

Хүснэгтээс харахад тайлант онд дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Дансны авлага, бусад авлага болон татварын авлагын нийт дүн өмнөх онтой харьцуулахад 37,394.5 сая төгрөгөөр буюу 65.0 хувиар өссөн байна. Нийт өсөлтийн 31,690.1 сая төгрөг буюу 85.0 хувийг дансны авлагын өсөлт бүрдүүлж байна. Дансны авлагын өсөлт нь нэхэмжлээгүй орлогын авлага (борлуулалтын орлогыг тайлант хугацаанд аккруэл сууриар бүртгэснээс үүссэн авлага) болон аж ахуйн нэгжээс авах дансны авлага байна. Тухайлбал цахилгаан эрчим хүчний аж ахуйн нэгжүүдтэй холбоотой авлагын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Түүнчлэн татварын авлага 6,123.1 сая төгрөгөөр өссөн нь нийт дансны өсөлтийн 16.4 хувийг

- эзэлж байна. Энэхүү өсөлтөд нэмэгдсэн өртгийн албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар авлагын өсөлт голлон нөлөөлсөн байна.
2. Бараа материалын данс өмнөх оноос 75.0 хувиар өссөнд үндсэн сэлбэг хэрэгслийн худалдан авалт буюу ухаалаг тоолуурын худалдан авалт нөлөөлсөн байна. Тайлант онд нийт 33,346.59 сая төгрөгийн өртөгтэй ухаалаг тоолуур худалдаж авсан бөгөөд үүнээс 8,970.9 сая төгрөгийн өртөгтэй ухаалаг тоолуур бараа материалын дансанд үлдэгдэлтэй байна.
 3. Үндсэн хөрөнгийн данс 130,273.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал:
 - Тайлант онд шинээр суурилуулж, ХЭС болон Гэрэл системд холбон хэвийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн 25,048.8 сая төгрөгийн өртөг бүхий ухаалаг тоолуур,
 - Их засвар болон техник, зохион байгуулалтын ажлын хүрээнд хийгдсэн 15,289.7 сая төгрөгийн ажлууд,
 - 30,484.1 сая төгрөгийн хувийн хэвшлийн хуулийн этгээд болон иргэдээс үнэ төлбөргүйгээр шилжин ирсэн шугам тоноглолууд,
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон 5,399.9 сая төгрөгийн хөрөнгө,
 - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар олж эзэмшсэн 1,361.9 сая төгрөгийн хөрөнгө болон тайлант хугацаанд худалдан авах ажиллагаа болон шууд худалдан авсан хөрөнгөөр тус тус нэмэгдсэн;
 - Тайлант хугацаан дахь хөрөнгийн өсөлттэй холбоотойгоор үндсэн хөрөнгөд нийт 28,810.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна. Харин тайлант хугацаанд ашиглалтын хугацаа дууссан, эвдэрч гэмтсэн 44,537.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан ба данснаас хассан хөрөнгөтэй холбоотойгоор 3,015.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг данснаас хассан байна.
 4. Биет бус хөрөнгө 17.05 хувиар өссөн нь шинээр суурилуулсан ухаалаг тоолуурын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор хүчин чадлын өсөлтийг хянах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор сервер болон программ хангамжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Мөн тайлант хугацаанд 795.32 сая төгрөгийн өртөг бүхий газар болон газрын эрхийг шинээр эзэмшсэн нь нөлөөлсөн.
 5. Дансны өглөг нь өмнөх оноосоо 94 хувиар буюу 53,487.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийн 85 хувь нь Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-д өгөх 45,487.5 сая төгрөгийн өглөг, 12.2 хувь нь ухаалаг тоолуур худалдан авахтай холбоотой бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх 6,526.4 сая төгрөгийн өглөг байна.
 6. Тус компанийн нийт зээлийн үлдэгдэл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 19,099.6 сая төгрөг байна. Тухайлбал:
 - Сангийн яам, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 16,239.2 сая төгрөгийн 6/20, жилийн 1.75 хувийн хүүтэй, хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж 0.5 хувийн хүүгийн нөхцөлтэй зээл олгосон байна. Тайлант онд 1,120.0 сая төгрөгийн үндсэн зээл, 122.5 сая төгрөгийн хүү төлж, жилийн эцсийн байдлаар 6,159.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй;
 - Сангийн яам, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 2006 оны 8 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 23.4 сая ам долларын зээлжих тусгай эрхтэй тэнцэх 3503 MOG дугаар бүхий дамжуулан зээлдүүлэх зээлийг 2012 оны 3 дугаар сарын 20-ны өдөр УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоолоор төгрөгт шилжүүлснээр гэрээг шинэчлэн байгуулсан бөгөөд эхний үе шатны зээлжих эрхийн валютыг төгрөгт шилжүүлснээр 30,129.5 сая төгрөгийг 8/35, жилийн 1.75 хувийн хүүтэй, хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж 0.5 хувийн хүүгийн нөхцөлтэй болсон. 2025 онд 1,229.8 сая төгрөгийн үндсэн зээл, 299.3 сая төгрөгийн хүү төлж, жилийн эцсийн байдлаар 12,912.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй;

- Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 1997 оны 8 дугаар сарын 11-ний өдөр байгууласан зээлийн хэлэлцээр, “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2006 оны 141 дүгээр тогтоол, 2009 оны 20 дугаар тогтоол, УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоол, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”, “Төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2011 оны 139 дүгээр тогтоол, “Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан 2011 оны 276/300 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр байгуулагдсан “Эрчим хүчний хэмнэлтийн төсөл”-ийн 1492 MON(SF), 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдөр нэмэлт өөрчлөлтөөр 92.2 сая төгрөгийг 8/35, жилийн 2 хувийн хүүтэй зээл авсан. Тайлант онд 4.6 сая төгрөгийн үндсэн зээл, 0.9 сая төгрөгийн хүү төлж, жилийн эцсийн байдлаар 27.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
7. Эздийн өмчийн данс 2.0 хувиар буюу 5,844.2 сая төгрөгөөр өссөн бөгөөд материаллаг нөлөө бүхий үлдэгдэл нь компанийн өмчийн данс, эздийн өмчийн бусад хэсэг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн үлдэгдэл байна. Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн 3,799.6 сая төгрөгөөр өмчийг нэмэгдүүлж, компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулснаар нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй, 2,508,787,038 ширхэг, 250,878.7 сая төгрөгийн өмчтэй болсон байна;
 8. Эздийн өмчийн бусад хэсэг данс тайлант онд цэвэр дүнгээр 57.7 хувиар буюу 3,796.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ТӨБЗГ-ын 421, 713 дугаар тогтоолоор бүртгэсэн нийт 7,595.8 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр өссөн, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор өмчийн дансанд бүртгэсэн 3,799.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна;
 9. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн данс тайлант онд данснаас хассан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн 536.7 сая төгрөгөөр буурсан.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/09 дүгээр тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, тайлант хугацаанд 3 удаа тодотгол хийсэн байна.

Тайлант оны нийт орлогыг 1,134,480.2 сая төгрөгөөр, зардлыг 1,132,994.3 сая төгрөгөөр, 1,485.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 31,169.3 сая төгрөг, ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төсөл 2-р шатны худалдан авалтад 36,000.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 1,191,666.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,188,532.9 сая төгрөгийн зардал гарган, 3,133.7 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай тайлагнасан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,191,666.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 57,186.4 сая төгрөг буюу 5.0 хувиар давсан нь тайлант онд 19.6 мянган хэрэглэгч нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,188,532.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 55,538.6 сая төгрөг буюу 4.9 хувиар хэтэрсэн байна.

Тайлант онд нийт 4,230.7 сая.квт цахилгаан худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 4,303.1 сая.квт цахилгаан худалдан авсан байна.

Худалдан авах цахилгааны өртгийг 957,828.2 сая төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд худалдан авсан цахилгааны биет хэмжээ 72.4 сая.квт-аар нэмэгдсэн, ЭХЗХ-ны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор нэгж худалдан авах өртөг 244.16 төг/квт.ц, 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 646 дугаар тогтоолоор 251.50төг/квт.ц болж өссөнтэй холбоотойгоор 1,010,387.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 201 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 30,963.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 744.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 592.7 сая төгрөгөөр дутуу байгаа нь тайлант хугацаанд орлогоос давсан зардал гаргаснаас шалтгаалсан байна.

Тайлант онд ТӨБЗГ-т цайны газар, заал болон 0.4кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын 175 ширхэг тулгуурын түрээсийн орлогын 40 хувь буюу 55.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд 369 төсөл, арга хэмжээнд 135,114.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, нээлттэй тендерээр 66 төсөл, арга хэмжээнээс 59 арга хэмжээг 123,545.9 сая төгрөгөөр, харьцуулалтын аргаар зохион байгуулах 60 төсөл арга хэмжээнээс 59 арга хэмжээг 3,151.1 сая төгрөгөөр, нэг эх үүсвэрийн худалдан авалтаар зохион байгуулах 5 төсөл арга хэмжээнээс 5 арга хэмжээг 1,282.0 сая төгрөгөөр, шууд худалдан авалтын аргаар зохион байгуулах 238 төсөл арга хэмжээнээс 229 худалдан авалтыг 3,654.3 сая төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

Тайлант оны эцэст нийт тендер шалгаруулалт 93.9, худалдан авалт 95.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Санхүүгийн тайлан аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

- Тайлант онд Тайланд улсын Бангкок хот дахь Esri фермийн албан ёсны сургалтын төвийн "Түгээх сүлжээний газар зүйн мэдээллийн систем"-ийн (ArcGIS) сургалт, Эрчим хүчний салбарын шинэчлэл хөгжил техникийн туслалцааны төслийн хүрээнд Гүрж улсын зах зээлийн үйл ажиллагаа, засаглал, удирдлага, тарифын аргачлал, өрсөлдөөнт зах зээл дэх туршлагаас судлах, Хиймэл оюун ухаан инновац: Ирээдүйн давллагааг давах "Inspur Digital Enterprise Innovation Conference-2025" зөвлөгөөнд оролцож, гадаад томилолтын зардалд нийт 28.7 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Тайлант онд хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний талаарх мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн 24 компанитай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, нийт 257.6 сая төгрөгийн хэвлэл, мэдээлэл, маркетингийн зардал гаргасан байна.
- Тайлант онд УБЦТС ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2023-2024 онд мөрдөх хамтын гэрээний 5.1 дүгээр заалтын хүрээнд нийт ажилтнуудад хоолны мөнгө өдрийн 12.0 сая төгрөг, унааны мөнгө өдрийн 2.0 сая төгрөгөөр тооцон олгож байгаа бөгөөд нийт 3,333.4 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Тайлант онд 138.4 сая төгрөгийг сургалтын зардалд зарцуулсан байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах хойшлуулсан НӨАТ-ын авлагын үлдэгдэлтэй харилцагчтай тооцоо нийлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг шивүүлэх, борлуулалт, худалдан авалтын НӨАТ-ыг цахим тайлангийн системийн дүнтэй тулган шалгах, нэмэгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжид төлсөн НӨАТ-ыг хуулийн дагуу хувь тэнцүүлэн бүртгэх, үйл ажиллагааны бус орлогын бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, аккруэл сууриар бүртгэх, техникийн алдагдлын гүйцэтгэлийн программыг баталгаажуулах, хөндлөнгийн хяналт хийх, ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан бараа материал, сэлбэг, тоног төхөөрөмжийн үнэд дүн шинжилгээ хийхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитын ахлах менежер Д.Нар-Од, аудитын менежер Г.Нандинцэцэг, ахлах аудитор Д.Бадамцэцэг, Ү.Цэцэгмаа, туслах аудитор Э.Цэнддорж, Ц.Мэндсайхан, Э.Нямдорж, Э.Хонгорзул, Ч.Хүслэн нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Шийлэгмаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1/276 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт орлогын 867,282.4 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 8,672.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан заалтын хүрээнд хэмнэлтийн зарчим баримталж, бүтэц орон тоог нэмэгдүүлээгүй, Хамтын гэрээний зарим заалтаас бусад зүйлсийн хувьд хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан “2023-2024 оны хамтын гэрээ”-ний нэмэлт өөрчлөлтийн 5 дугаар зүйлийн 5.19-д “Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цөөрүүлэх, орон тоо цомхотгох, хувьчлагдах тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор өмчийн хэлбэр үл харгалзан уг ажилтанд **эрчим хүчний салбарт** 1-4 ажилласан бол 4 сар, 5-10 жил ажилласан бол 8 сар, 11-15 жил ажилласан бол 12 сар, 16-аас дээш жил ажилласан бол 24 сарын **дундаж цалинтай** тэнцэх хэмжээний тэтгэмжийг бодож олгоно” гэж заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлд “Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийн холбогдох заалтад уг тэтгэмжийг **тухайн аж ахуйн нэгж,**

байгууллагад ажилласан хугацааг харгалзан үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.21-д “Эрчим хүчний тэргүүний ажилтан болон тус салбарт ажиллаж байгаа бусад салбарын тэргүүний ажилтанд давхардуулахгүйгээр 15,000 (арван таван мянган) төгрөгийн, гавьяат ажилтан, төрийн шагналтанд 30,000 (гучин мянган) төгрөгийн, хөдөлмөрийн баатарт 50,000 (тавин мянган) төгрөгийн урамшууллыг сар бүр олгоно” гэж заасныг үндэслэн тайлант онд хамтын гэрээний 3.21-д заасны дагуу нийт 121.4 сая төгрөг олгосон байна. Энэ Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1 дүгээр хавсралтын 1.7-д “Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,030.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 5 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Илрүүлэлт 1. Шилэн дансны нэгдсэн цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 396 харилцагчийн 71,027.9 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлэхээс 2,656.1 сая төгрөгийн 122 харилцагчийн худалдан авалтыг мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой хэрэгжилттэй холбоотой асуудал

Албан шаардлага:

Илрүүлэлт 2. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 272.4 сая төгрөгийн 4 худалдан авалтын тендер шалгаруулалтын зарлал, тендерийн бичиг баримтад үнийн санал дуудах ажиллагаа нь 1-ээс дээш оролцогчтой байх шаардлагыг тусгасан боловч зөвхөн нэг оролцогч үнийн санал ирүүлж, тухайн оролцогчийг харьцуулалтгүйгээр сонгож, худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, САГ-2026/71/НА-СТА-ТӨҮГ

үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно”, 34.2.1-т “үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоо” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харьцуулалтын аргаар нэгээс дээш оролцогчтой байх шаардлагатайгаар зарласан худалдан авах ажиллагаанд зөвхөн нэг оролцогч үнийн санал ирүүлснийг шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 9 худалдан авах ажиллагааны цахим системээс илгээсэн татварын тодорхойлолтоор аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын өглөгийн мэдээлэл татагдаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөгийн мэдээлэл татагдсан нь хуулийн дагуу тендерт оролцогч нь ерөнхий шаардлага хангасан, татварын өртэй эсэхийг тодорхойлох боломжгүй, ашиглалт засварын баруун, зүүн төвийн конторын засварын 102.3 сая төгрөгийн ажлын тендер шалгаруулалтын зааварчилгааны хүний нөөцийн шаардлагыг хангасныг нотлох баримтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3-т “гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл”, 34 дүгээр зүйлийн 34.1-т “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно”, 34.2.1-т “үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоо” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн бичиг баримтад тусгасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримтыг бүрэн бүрдүүлэхгүйгээр тендер шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Бараа материал сэлбэг, тоног төхөөрөмж худалдан авах 5 тендер нь бараа тус бүрээр үнийг харьцуулалгүй нийт дүнгээр нь харьцуулалт хийдэг, тендерийн бичиг баримтад тусгасан бүх нөхцөл, шаардлагуудыг тус бүрээр нь тусгасан үнэлгээний хуудас бэлтгэдэггүй, нэр бүхий нэг компанийг нэг багц дээр сонгон шалгаруулсан ч өөр нэг багцын хувьд тендерийн шаардлага хангаагүй гэж өөр хоорондоо эсрэгцсэн шийдвэр гаргасан, тендерт оролцогчоос ирүүлсэн дээжид хийсэн туршилтын комиссын дүгнэлтийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ”, 27 дугаар зүйлийн 27.5-д “Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал сэлбэг, тоног төхөөрөмж худалдан авахдаа бараа тус бүрээр үнийн харьцуулалт хийгээгүй, тендерийн бичиг баримтад тусгасан бүх нөхцөл, шаардлагуудыг тус бүрээр нь үнэлээгүй, үнэлгээний хороо нь өөр хоорондоо зөрүүтэй шийдвэр гаргадаг зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгслийн худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээгээр Төрийн худалдан авах ажиллагааны газраар зохион байгуулуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7-д “Энэ хуулийн 4.1.8-д заасан ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 162 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ын 16-д “Эрчим хүчний салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл” гэж заасантай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгслийг ерөнхий гэрээгээр Төрийн худалдан авах ажиллагааны газраар зохион байгуулуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

Илрүүлэлт 6. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бараа материал, сэлбэг, тоног төхөөрөмжийн үнийг харилцагч байгууллагуудаас үнийн санал авч, судалгаа хийсэн боловч тухайн бараа материалын худалдан авалтын үнийг 2023 оны 9 дүгээр сараас хойш бараа материалын тайлан буюу бодит худалдан авалтын түүхэн үнэд дүн шинжилгээ хийж, үнийн өөрчлөлт хийгээгүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авч бараа материалд орлогоор бүртгэсэн үнэтэй харьцуулахад 4 төрлийн дугуй (215/75/R14, 235/70/R16, 265/70/R15, 7.00/R16)-ны нэгжийн үнэ 31%-45% -аар, Төгсгөлийн муфть (ЗКНТп-10-25/50, ЗКНТп-10-70/120) -ний нэгж үнэ 124%-136%-аар, 5 төрлийн Кабель (АВВГ 3x35+1x16, АВБ6ШВ 3x70+1x35, ААБл 3x240, 150,120)-ний нэгж үнэ 29%-134%-аар төлөвлөснөөс илүү үнээр, 4 төрлийн дугуй (245/70/R19.5,265/65/R17,285/60/R18, 9.00/R20)-ны нэгжийн үнэ 11%-19%-аар, Холболтын муфть (4СТп-1-25/50, ЗПСТБЛ-10-150/240) -ний нэгж үнэ 20%-23%-аар төлөвлөснөөс бага үнээр бүртгэгдсэн болон кабель АВБ6ШВ 3x120+1x70-ийг кабель АВБ6ШВ 3x120+1x70-ийг 2 өөр үнээр бүртгэгдсэн байна. төлөвлөсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах бараа материал, сэлбэг, тоног төхөөрөмжийн үнэд дүн шинжилгээ хийж, бодитой тогтоож байх зөвлөмж хүргүүлээ.

Илрүүлэлт 7. Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс техникийн алдагдлын гүйцэтгэл, төлөвлөлтийг Лосс-10.0 программаар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд техникийн алдагдлын гүйцэтгэлийн Лосс-4.0 программаар тус тус гаргаж байна. Тус программыг 2007 оноос хойш ашиглаж байгаа боловч өнөөдрийг хүртэл шинэчлэл хийгээгүй, техникийн алдагдлын тооцооллын үнэн зөв байдлыг баталгаажуулах хөндлөнгийн хяналт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Техникийн алдагдлын гүйцэтгэл төлөвлөлтийг тодорхойлж буй Лосс-10.0 болон Лосс-4.0 программын тооцооллыг хөндлөнгийн хяналтаар оруулж магадлан шалгуулах зөвлөмжийг өглөө.

Илрүүлэлт 8. Гүйцэтгэх захирлын 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/223 дугаар тушаалаар баталсан "Найдваргүй авлага болон бараа материалын үлдэгдэлд тооцох хасагдуулгын хувь хэмжээ"-г мөрдөж, авлагын үнэ цэний бууралт буюу хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал тооцсон боловч энэ нь СТОУС болон компанийн баталсан НБББББ-тэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компани өөрийн нөөц боломжийг ашиглан, зардал гаргахгүй түүхэн мэдээлэл, авлагын насжилт, СТОУС болон компанийн баталсан НБББББ-тэй нийцүүлэн боловсруулж батлуулан дагаж мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус компанийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, өртөг, зардал, худалдан авалт зэрэг данснуудад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг компанийн удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн 50,524.3 сая төгрөгийн 7 алдааг санхүүгийн тайланд залруулж, 6,441.7 сая төгрөгийн 3 алдааг залруулах зөвлөмж, 9.9 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах зөвлөмжийг тус тус өгсөн байна. Жилийн эцсийн аудитаар илэрсэн асуудлыг дахин хянаж, биелэлт хангалтгүй 6,441.7 сая төгрөгийн 2 зөрчлийг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 12,762.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх 12,505.5 сая төгрөгийн 10 албан шаардлага, цаашид сайжруулан ажиллах 256.7 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Гүйцэтгэх захирлын “2024 оны санхүүгийн тайлан тэнцэлд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/416 дугаар тушаалаар баталж, Үндэсний аудитын газарт хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 1/508 дугаар албан бичгээр нотлох баримтын хамт хүргүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	10	12,505,474.9	10	12,505,474.9	100.0
Зөвлөмж	5	256,687.1	5	256,687.1	100.0
Нийт дүн	15	12,762,162.0	15	12,762,162.0	100.0

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Компани нь үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансанд санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал болон НББОУС 12 “Орлогын татвар”-ын дагуу хойшлогдсон татварын өр төлбөр, хойшлогдсон татварын зардлыг бүртгэх ба өнгөрсөн тайлант жилүүдэд "Tax Ass 1.0", тайлант онд veritich ERP программаар санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг бүртгэсэн бөгөөд энэхүү хойшлогдсон татварын өр төлбөрийн дэлгэрэнгүй тооцооллыг дараагийн аудитаар анхаарч үзэх;
- Компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй 205,207 ширхэг 11,746.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 9,452.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2,293.8 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгүүд, мөн элэгдлээрээ анхны өртөг бүрэн нөхсөн 1,366,199.49 ширхэг (урт метр) үндсэн хөрөнгийн данснаас хасах болон дахин үнэлүүлэх саналыг Төлөөлөн удирдах зөвлөх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх;

- Их болон урсгал засварын бүртгэл тайлагнал нь холбогдох дүрэм журамтай нийцэж буй эсэх, урсгал засварын дүн нь тухайн хөрөнгийн дансны үнийн хэдэн хувьтай тэнцэж буй эсэхийг дараагийн аудитаар анхаарах;
- Тайлант оны эцэст угсарч суурилуулсан гүйцэтгэлийн акт гараагүй 32,860 ширхэг ухаалаг тоолуурыг дараагийн онд хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн эсэхийг анхаарч үзэх;
- Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2023-2024 оны “Хамтын гэрээ”-ний 5 дугаар зүйлийн 5.16-д “Тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарснаас хойш нийгмийн даатгалын шимтгэл төлж эрчим хүчний салбарт ажилласан жил (сард) тухайн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр бодож нэг удаагийн тэтгэмж олгоно” гэж заасны дагуу ажилтанд тэтгэвэрт гарах үед нь тэтгэмжийг тооцон олгож, ажилтны тэтгэмжид зориулсан нөөц ба өр төлбөрийг санхүүгийн тайландаа тусгаж бүртгээгүй бөгөөд дараагийн аудитаар ажилтанд тэтгэвэрт гарах үед олгох тэтгэмжийг тарифт суулган НББОУС 19 “Ажилтны тэтгэмж”-ийн дагуу тооцоолон бүртгэсэн эсэхийг хянах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,138.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Ухаалаг тоолууртай холбоотой үүссэн урт хугацаат хойшлуулсан орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байгаа нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 69-р параграф, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй,
- Суудлын автомашины худалдан авалтын НӨАТ-ыг хөрөнгийн өртөгт бүртгээгүй, төлөх НӨАТ-ын дүнг бууруулсан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй,
- Тайлант онд нэр бүхий 5 харилцагчаас гэрээнд заасны дагуу 4 харилцагчийн чанарын баталгааны барьцааг барьцааны өглөгөөр ангилан бүртгээгүй байгаа нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 69-р параграф, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй,
- Худалдан авалтын НӨАТ-ын дүнг дутуу бүртгэж, бараа материалын өртгийг илүү бүртгэсэн нь үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Аудитаар нийт 12,702.1 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 12,268.9 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 433.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,702.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,029.3 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Тайланд онд татварын цахим төлбөрийн баримтын системд зөрүүтэй буюу давхардуулж бүртгэсэн 1,164.3 сая төгрөгийн борлуулалтын төлбөрийн баримтыг буцаасан боловч харилцагч хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй дүнгээр нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд борлуулалтын орлогыг илүү тайлагнаж, 116.4 сая төгрөгийн татварыг илүү төлсөн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно”, 17.6-д “албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын цахим төлбөрийн баримтын системд цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлогыг зөрүүтэй буюу давхардуулж бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт 2. Тайланд онд хуримтлагдсан ашиг, алдагдал дансанд өмнөх жилд орлого, зардлаар бүртгэх 4,312.5 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг материаллаг хэмжээний алдаатай илэрхийлж хуримтлагдсан ашиг, алдагдалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт 3. Компанийн бүртгэлд тусгасан Нэмэгдсэн өртгийн албан татварын авлагын үлдэгдэл, татварын цахим тайлангийн системийн үлдэгдлээс 468.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7-д “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт, борлуулалтын Нэмэгдсэн өртгийн албан татварын гүйлгээг татварын цахим тайлангийн дүнтэй тулган шалгаагүй, авлагын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлсэн.

Илрүүлэлт 4. Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс 6,358.9 сая төгрөгөөр зөрүүтэй буюу илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.3.3-т “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Илрүүлэлт 5. Цахим төлбөрийн баримтын системд зарим харилцагчид гаргасан төлбөрийн баримт болгоогүй, төлбөрийн баримт давхар шивсэн 380.5 сая төгрөгийн нэхэмжлэх бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10-т "Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим төлбөрийн баримт болгоогүй, төлбөрийн баримт давхардуулан шивсэн зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Илрүүлэлт 6. Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хойшлогдсон орлогын үлдэгдэл, хүлээн зөвшөөрөлтийг уг орлоготой холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн элэгдэл, үлдэх өртөгтэй уялдуулан бүртгээгүй, аудитад ирүүлсэн материалын хүрээнд хөрөнгийн үлдэх өртөг, хойшлогдсон орлогын үлдэгдлээс 352.6 сая төгрөгөөр зөрүүтэй, тайлант жилд хүлээн зөвшөөрч бүртгэсэн үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг тухайн хөрөнгийн байгуулсан элэгдлийн дүнгээс 108.1 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хойшлогдсон орлогыг зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Илрүүлэлт 7. Ковид цар тахлын үед үүссэн Хан-Уул хэрэглэгчдэд үйлчлэх төвийн 79.4 сая төгрөгийн, Налайх төвийн 19.2 сая төгрөгийн хогны хураамжийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүү байдлын тайланд бүртгэлтэй хогны хураамжийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Илрүүлэлт 8. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс худалдах, худалдан авах үйлчилгээ авч буй 80 хэрэглэгчийн 2024-2025 онд үүссэн 72.8 сая төгрөгийн өр төлбөрийг санхүү бүртгэлд хэрэглэгч тус бүрээр бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.7-д "энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын журмын шаардлага хангасан хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр энэ хуулийн 17.3-т заасан гэрээг САГ-2026/71/НА-СТА-ТӨҮГ

байгуулж, тухайн хэрэглэгчийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох", 17 дугаар зүйлийн 17.3-д "Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх зарим хэрэглэгчдийн цахилгаан, дулааны борлуулалтыг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээт борлуулагчид худалдах үнэ, төлөх шимтгэлийг хоорондын гэрээгээр тохиролцох ба хэрэглэгчид Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнээр худалдана", Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 28 дугаар тогтоолын 2-т "Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс худалдах, худалдан авах үйлчилгээ авч буй хэрэглэгчидтэй тооцоо нийлж, санхүү бүртгэлд өр төлбөр үүсгэн бүртгээгүй зөрчлийг арилгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. **Үүнд:**

1. Үйл ажиллагааны бус орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Байгууллага нь бусад орлогын дансанд бүртгэж буй төсвөөр гүйцэтгэсэн гэрээт ажлын үйлчилгээний орлого, алданги торгуулийн орлого болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хохирлын акт тогтоогдсон үед нь бус харин төлбөр төлөгдсөн үед орлогоор бүртгэж, орлогын бүртгэлд тавих дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь СТОУС 15 "Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого" параграф 31 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээт ажлын үйлчилгээний орлогыг аккруэл суурийн дагуу хүлээн зөвшөөрч бүртгэх, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах.

2. Хойшлуулсан НӨАТ-ын авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Хойшлуулсан НӨАТ-ын авлагын үлдэгдлийн дүнд 2021-2024 оны хооронд үүссэн харилцагчаас төлбөрийн баримтыг цаг хугацаанд нь шивүүлээгүй 391.1 сая төгрөгийн хойшлуулсан НӨАТ-ын авлага бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримтыг харилцагчаас авч чадаагүй тооцооны дүнгээр компанийн зардал өсөж, ашиг буурах эрсдэлтэй тул НӨАТ-ын авлагын үлдэгдэлтэй харилцагчтай тооцоо нийлж, худалдан авалтын НӨАТ-ыг шивүүлж, НӨАТ-ын тайланд тусгах.

3. Хувь тэнцүүлсэн НӨАТ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Тайланд онд нэмэгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж нь ихэвчлэн их засвар болон төслийн хүрээнд бий болсон бөгөөд энэхүү нэмэгдсэн хөрөнгөтэй холбоотой бараа материалд төлсөн НӨАТ-ыг хасагдах НӨАТ-өөр тайлагнасан ба Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хувь тэнцүүлэн бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д "үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авах, импортлоход төлсөн албан татварыг дараах хугацаагаар хувь тэнцүүлэн хасагдуулна", 14.1.5.а-д "барилга, байгууламж 10 жилээр", 14.1.5.б-д "тоног төхөөрөмж 5 жилээр", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Татварын ерөнхий хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д "дараах үйлдэл, эс үйлдлийн улмаас төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно", 84.1.5-д "төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулах, эсхүл буцаан авах татварын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын падаан, төлбөрийн баримтын мэдээллийг зөрүүтэй гаргасан, эсхүл падаан, төлбөрийн баримтыг үйлдээгүй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, хуулийн заалтыг хэрхэн мөрдөх талаар татварын байгууллагаас тайлбар тодруулга авч хэрэгжүүлэх нь компанид татварын нөхөн төлбөр, алданги торгуулийн эрсдэлгүй гэдгийг анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган, төгрөгөөр/					
							Үүнээс		Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ухаалаг тоолууртай холбоотой үүссэн урт хугацаат хойшлуулсан орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй.	1	19,500,071.1	-	-	1	19,500,071.1	1	19,500,071.1	-	-	-	-
Суудлын автомашины худалдан авалтын НӨАТ-ыг хөрөнгийн өртөгт бүртгээгүй, төлөх НӨАТ-ын дүнг бууруулсан.	1	102,540.0	-	-	1	102,540.0	1	102,540.0	-	-	-	-
Тайлант онд нэр бүхий 4 харилцагчийн чанарын баталгааны барьцаа болох 5 хувь 1,519.9 сая төгрөгийн дүнг барьцааны өглөгөөр ангилан бүртгээгүй. Үүний 243.7 сая төгрөгийн өглөг нь богино хугацаат барьцааны өглөг, 1,276.2 сая төгрөгийн өглөг нь урт хугацаат барьцааны өглөг байна.	1	1,519,879.2	-	-	1	1,519,879.2	1	1,519,879.2	-	-	-	-
Ухаалаг тоолуур худалдан авалтын НӨАТ-ын дүнг дутуу үүсгэж, БМ-ын өртгийг илүү бүртгэсэн.	1	16,200.1	-	-	1	16,200.1	1	16,200.1	-	-	-	-
Дүн	4	21,138,690.4	-	-	4	21,138,690.4	4	21,138,690.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хан-Уул ХҮТ-ийн 79.4 сая төгрөгийн, Налайх төвийн 19.2 сая төгрөгийн хогны хураамжийн ковид цар тахлын үед үүссэн авлага тооцоо нийлэлтээр баталгаажуулахгүй, төлөгдөх хугацаа хэтрээд 5 жил болсон ч авлагын хүлээгдэж буй эрсдэлийн сан тооцоогүй.	1	98,629.9			1	98,629.9						
Хойшлуулсан НӨАТ-ын авлагын үлдэгдлийн дүнд 2021-2024 оны хооронд үүссэн харилцагчаас төлбөрийн баримтыг цаг хугацаанд нь шивүүлээгүй НӨАТ-ын авлага бүртгэсэн.	1	391,093.7					1	391,093.7				
Татварын цахим төлбөрийн баримтын системд зөрүүтэй буюу давхардуулж бүртгэсэн борлуулалтын төлбөрийн баримтыг буцаасан боловч харилцагч хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй уг дүнгээр борлуулалтын орлого НӨАТ-ын тайланд илүү тусгагдаж 116.4 сая төгрөгийн НӨАТ-ыг илүү төлсөн.	1	116,434.0			1	116,434.0						
Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдэл санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дүнгээс 6,358.9 сая төгрөгөөр зөрүүтэй.	1	6,358,859.2			1	6,358,859.2						
Тайланд онд нэмэгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой бараа материалд төлсөн НӨАТ-ыг хасагдах НӨАТ-өөр тайлагнасан ба НӨАТ-ын хуулийн дагуу хувь тэнцүүлэн бүртгэж, тайлагнаагүй.	1	-					1	-				

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Компанийн бүртгэлд тусгасан НӨАТ-ын авлагын дансны үлдэгдэл, НӨАТ-ын тайлан буюу цахим тайлангийн системийн үлдэгдлээс илүү байна.	1	468,609.9			1	468,609.9					
Цахим төлбөрийн баримтын системд зарим харилцагчид гаргасан төлбөрийн баримт болгоогүй, төлбөрийн баримт давхар шивсэн 380.5 сая төгрөгийн нэхэмжлэх бүртгэлтэй.	1	380,525.8			1	380,525.8					
Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс худалдах, худалдан авах үйлчилгээ авч буй 80 хэрэглэгчдийн 2024 болон 2025 онуудын 72.8 сая төгрөгийн өглөгийг санхүү бүртгэлд хэрэглэгч тус бүрээр өглөг үүсгэж бүртгээгүй.	1	72,758.6			1	72,758.6					
Тайланд онд хуримтлагдсан ашиг, алдагдал дансанд өмнөх жилийн нягтлан бодох бүртгэлийн алдаатай холбоотой өмнөх тайлант жилд орлого, зардлаар бүртгэх 4,312.5 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байгаа нь татварын болон бүртгэлийн эрсдэлтэй байна.	1	4,312,451.0			1	4,312,451.0					
Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хойшлогдсон орлогын үлдэгдэл, хүлээн зөвшөөрөлтийг уг орлоготой холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн элэгдэл, үлдэх өртөгтэй уялдуулан бүртгээгүй, аудитад ирүүлсэн материалын хүрээнд хөрөнгийн үлдэх өртөг, хойшлогдсон орлогын үлдэгдлээс 352.6 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Тайлант жилд хүлээн зөвшөөрч бүртгэсэн үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг тухайн хөрөнгийн байгуулсан элэгдлийн дүнтэй тулган шалгахад 108.1 сая төгрөгөөр илүү бүртгэсэн.	1	460,652.9			1	460,652.9					
Байгууллага нь бусад орлогын дансанд бүртгэж буй төсвөөр гүйцэтгэсэн гэрээт ажлын үйлчилгээний орлого, алданги торгуулийн орлого болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хохирлын акт тогтоогдсон үед нь бус харин төлбөр төлөгдсөн үед орлогоор бүртгэж байна. Мөн эдгээр орлогын бүртгэлд тавих дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй.	1	42,107.4					1	42,107.4			
Дүн	11	12,702,122.4			8	12,268,921.3	3	433,201.1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд 396 харилцагчийн 71,027.9 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлэхээс 2,656.1 сая төгрөгийн 122 харилцагчийн худалдан авалтыг мэдээллийг байршуулаагүй байна.	1	2,656,055.9	-	-	1	2,656,055.9	-	-
Дүн	1	2,656,055.9	-	-	1	2,656,055.9	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар зохион байгуулсан худалдан авалтаас түүвэрлэн шалгахад нийт 272.4 сая мянган төгрөгийн 4 арга хэмжээг "үнийн санал дуудах ажиллагаанд 1-ээс дээш" оролцогчтой байх шаардлагыг тендер шалгаруулалтын зарлал, тендерийн баримт бичигт тусгасан хэдий ч зөвхөн нэг оролцогч үнийн санал ирүүлсэн байхад тухайн оролцогчийг харьцуулалтгүйгээр шалгаруулж худалдан авалт хийсэн	1	272,458.8	-	-	1	272,458.8	-	-
Нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан нийт 9 худалдан авалтын цахим системээс илгээсэн татварын тодорхойлолтоор Аж ахуй нэгжийн орлогын албан татварын өглөгийн мэдээлэл татагдаагүй НӨАТ-ын өглөг, Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөгийн мэдээлэл татагдсан байгаа нь татварын өртэй эсэх, хуулийн дагуу тендер оролцогч нь ерөнхий шаардлага хангасан эсэхийг тодорхойлох боломжгүй, ашиглалт засварын баруун, зүүн төвийн конторын засварын 102.3 сая төгрөгийн ажлын тендер шалгаруулалтын зааварчилгааны хүний нөөцийн шаардлагыг хангасныг нотлох баримтгүй байна.	1	102,259.5	-	-	1	102,259.5	-	-
Бараа материал сэлбэг, тоног төхөөрөмж худалдан авах 5 тендер нь бараа тус бүрээр үнийг харьцуулалгүй нийт дүнгээр нь харьцуулалт хийдэг, тендерийн бичиг баримтад тусгасан бүх нөхцөл, шаардлагуудыг тус бүрээр нь тусгасан үнэлгээний хуудас бэлтгэдэггүй, нэр бүхий нэг компанийг нэг багц дээр сонгон шалгаруулсан ч өөр нэг багцын хувьд тендерийн шаардлага хангаагүй гэж өөр хоорондоо эсрэгцсэн шийдвэр гаргасан, тендер	1	-	-	-	1	-	-	-

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

оролцогчоос ирүүлсэн дээжид хийсэн туршилтын комиссын дүгнэлтийг баталгаажуулаагүй.								
Компани нь эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгслийн худалдан авалтыг Монгол улсын Засгийн газраас баталсан 2024 оны 4 сарын 17-ны өдрийн 162 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газраар зохион байгуулуулаагүй.	1	-	-	-	1	-	-	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа материал, сэлбэг, тоног төхөөрөмжийн үнийг харилцагч байгууллагуудаас үнийн санал авч судалгаа явуулдаг ч тухайн бараа материалын худалдан авалтын үнийг 2023 оны 9-р сараас хойш бараа материалын тайлан буюу бодит худалдан авалтын түүхэн үнэд дүн шинжилгээ хийж үнийн өөрчлөлт хийгээгүй	1	-	-	-	-	-	1	-
Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс нь техникийн алдагдлын гүйцэтгэл төлөвлөлтийг Лосс-10.0 программаар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд техникийн алдагдлын гүйцэтгэлийн Лосс-4.0 программаар тус тус гаргаж байна. Уг программыг 2007 оноос хойш хэрэглэж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл шинэчлэл хийгдээгүй, техникийн алдагдлын тооцооллын үнэн зөв байдлыг баталгаажуулах хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Гүйцэтгэх захирлын 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/223 тоот тушаалаар баталсан "Найдваргүй авлага болон бараа материалын үлдэгдэлд тооцох хасагдуулгын хувь хэмжээ" -г мөрдөж авлагын үнэ цэнийн бууралт буюу хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал тооцож байгаа ч энэ нь СТОУС болон компанийн батлагдсан НБББББ-тэй нийцээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	7	374,718.3			4	374,718.3	3	0
Нийт дүн	8	3,030,774.2			5	3,030,774.2	3	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 614/A0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/71/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материал сэлбэг, тоног төхөөрөмж худалдан авах 5 тендер нь бараа тус бүрээр үнийг харьцуулалгүй нийт дүнгээр нь харьцуулалт хийдэг, тендерийн бичиг баримтад тусгасан бүх нөхцөл, шаардлагуудыг тус бүрээр нь тусгасан үнэлгээний хуудас бэлтгэдэггүй, нэр бүхий нэг компанийг нэг багц дээр сонгон шалгаруулсан ч өөр нэг багцын хувьд тендерийн шаардлага хангаагүй гэж өөр хоорондоо эсрэгцсэн шийдвэр гаргасан, тендерт оролцогчоос ирүүлсэн дээжид хийсэн туршилтын комиссын дүгнэлтийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ", 27 дугаар зүйлийн 27.5-д "Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Бараа материал сэлбэг, тоног төхөөрөмж худалдан авахдаа бараа тус бүрээр үнийн харьцуулалт хийгээгүй, тендерийн бичиг баримтад тусгасан бүх нөхцөл, шаардлагуудыг тус бүрээр нь үнэлээгүй, үнэлгээний хороо нь өөр хоорондоо эсрэгцсэн шийдвэр гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга (Ж.Хосбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 615/A0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/71/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгслийн худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээгээр Төрийн худалдан авах ажиллагааны газраар зохион байгуулуулаагүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7-д “Энэ хуулийн 4.1.8-д заасан ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 162 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ын 16-д “Эрчим хүчний салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”, 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгслийг ерөнхий гэрээгээр Төрийн худалдан авах ажиллагааны газраар зохион байгуулуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга (Ж.Хосбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 616/А0150092

Улаанбаатар хот

САГ - 2026 / 71 / ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковид цар тахлын үед үүссэн Хан-Уул хэрэглэгчдэд үйлчлэх төвийн 79,396,000.00 (Далан есөн сая гурван зуун ерэн зургаан мянган) төгрөгийн, Налайх төвийн 19,233,900.00 (Арван есөн сая хоёр зуун гучин гурван мянга есөн зуун) төгрөгийн хогны хураамжийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Санхүү байдлын тайланд бүртгэлтэй хогны хураамжийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 617/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА -СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хойшлогдсон орлогын үлдэгдэл, хүлээн зөвшөөрөлтийг уг орлоготой холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн элэгдэл, үлдэх өртөгтэй уялдуулан бүртгээгүй, аудитад ирүүлсэн материалын хүрээнд хөрөнгийн үлдэх өртөг, хойшлогдсон орлогын үлдэгдлээс 352,579,075.73 (Гурван зуун тавин хоёр сая таван зуун далан есөн мянга далан таван төгрөг далан гурван мөнгө)-өөр зөрүүтэй бүртгэсэн;
- Тайлант жилд хүлээн зөвшөөрч бүртгэсэн үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг тухайн хөрөнгийн байгуулсан элэгдлийн дүнгээс 108,073,798.96 (Нэг зуун найман сая далан гурван мянга долоон зуун ерэн найман төгрөг ерэн зургаан мөнгө)-өөр илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Хойшлогдсон орлогыг зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 618/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026/71/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 2,656,055,890.74 (Хоёр тэрбум зургаан зуун тавин зургаан сая тавин таван мянга найман зуун ерэн төгрөг далан дөрвөн мөнгө)-ний 122 харилцагчийн худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч (А. Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 619/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА -СТА -ТӨҮТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс худалдах, худалдан авах үйлчилгээ авч буй 80 хэрэглэгчийн 2024-2025 онд үүссэн 72,758,560.38 (Далан хоёр сая долоон зуун тавин найман мянга таван зуун жаран төгрөг гучин найман мөнгө)-ний өр төлбөрийг санхүү бүртгэлд хэрэглэгч тус бүрээр бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.7-д "энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын журмын шаардлага хангасан хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр энэ хуулийн 17.3-т заасан гэрээг байгуулж, тухайн хэрэглэгчийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох", 17 дугаар зүйлийн 17.3-д "Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх зарим хэрэглэгчдийн цахилгаан, дулааны борлуулалтыг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээт борлуулагчид худалдах үнэ, төлөх шимтгэлийг хоорондын гэрээгээр тохиролцох ба хэрэглэгчид Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнээр худалдана", Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 28 дугаар тогтоолын 2-т "Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс худалдах, худалдан авах үйлчилгээ авч буй хэрэглэгчидтэй тооцоо нийлж, санхүү бүртгэлд өр төлбөр үүсгэн бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 620/АДИ50092

Улаанбаатар хот

САГ - 2026/71/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 272,452,800.00 (Хоёр зуун далан хоёр сая дөрвөн зуун тавин хоёр мянга найман зуун) төгрөгийн 4 худалдан авалтын тендер шалгаруулалтын зарлал, тендерийн бичиг баримтад үнийн санал дуудах ажиллагаа нь 1-ээс дээш оролцогчтой байх шаардлагыг тусгасан боловч зөвхөн нэг оролцогч үнийн санал ирүүлж, тухайн оролцогчийг харьцуулалтгүйгээр сонгож худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", 34.2.1-т "үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоо" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьцуулалтын аргаар нэгээс дээш оролцогчтой байх шаардлагатайгаар зарласан худалдан авах ажиллагаанд зөвхөн нэг оролцогч үнийн санал ирүүлснийг шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга (Ж.Хосбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 621/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026 / 71 / ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 9 худалдан авах ажиллагааны цахим системээс илгээсэн татварын тодорхойлолтоор аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын өглөгийн мэдээлэл татагдаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөгийн мэдээлэл татагдсан нь хуулийн дагуу тендерт оролцогч нь ерөнхий шаардлага хангасан, татварын өртэй эсэхийг тодорхойлох боломжгүй, ашиглалт засварын баруун, зүүн төвийн конторын засварын 102,259,480.00 (Нэг зуун хоёр сая хоёр зуун тавин есөн мянга дөрвөн зуун наян) төгрөгийн ажлын тендер шалгаруулалтын зааварчилгааны хүний нөөцийн шаардлагыг хангасныг нотлох баримтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3-т "гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", 34.2.1-т "үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоо" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендерийн бичиг баримтад тусгасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримтыг бүрэн бүрдүүлэхгүйгээр тендер шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга (Ж.Хосбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 622/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим төлбөрийн баримтын системд зарим харилцагчид гаргасан төлбөрийн баримт болгоогүй, төлбөрийн баримт давхар шивсэн 380,525,785.10 (Гурван зуун наян сая таван зуун хорин таван мянга долоон зуун наян таван төгрөг арван мөнгө) төгрөгийн нэхэмжлэх бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10-т "Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Цахим төлбөрийн баримт болгоогүй, төлбөрийн баримт давхардуулан шивсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 623/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА-СТА-ТӨҮТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс 6,358,859,212.92 (Зургаан тэрбум гурван зуун тавин найман сая найман зуун тавин есөн мянга хоёр зуун арван хоёр төгрөг ерэн хоёр мөнгө)-өөр зөрүүтэй буюу илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.3.3-т "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 624/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн бүртгэлд тусгасан Нэмэгдсэн өртгийн албан татварын авлагын үлдэгдэл, татварын цахим тайлангийн системийн үлдэгдлээс 468,609,951.94 (Дөрвөн зуун жаран зургаан сая зургаан зуун есөн мянга есөн зуун тавин нэг төгрөг ерэн дөрвөн мөнгө)-өөр илүү тайлагнагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.7-д "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Худалдан авалт, борлуулалтын Нэмэгдсэн өртгийн албан татварын гүйлгээг татварын цахим тайлангийн дүнтэй тулган шалгаагүй, авлагын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 625/А0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/71/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд хуримтлагдсан ашиг, алдагдал дансанд өмнөх жилд орлого, зардлаар бүртгэх 4,312,451,047.12 (Дөрвөн тэрбум гурван зуун арван хоёр сая дөрвөн зуун тавин нэгэн мянга дөчин долоон төгрөг арван хоёр мөнгө)-ний нягтлан бодох бүртгэлийн алдааг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Нягтлан бодох бүртгэлийг материаллаг хэмжээний алдаатай илэрхийлж хуримтлагдсан ашиг, алдагдалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 626/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд татварын цахим төлбөрийн баримтын системд зөрүүтэй буюу давхардуулж бүртгэсэн 1,164,339,992.60 (Нэг тэрбум нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун гучин есөн мянга есөн зуун ерэн хоёр төгрөг жаран мөнгө) төгрөгийн борлуулалтын төлбөрийн баримтыг буцаасан боловч харилцагч хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй дүнгээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд борлуулалтын орлогыг илүү тайлагнаж, 116,433,999.26 (Нэг зуун арван зургаан сая дөрвөн зуун гучин гурван мянга есөн зуун ерэн есөн төгрөг хорин зургаан мөнгө)-ний татварыг илүү төлсөн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно”, 17.6-д “албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-15 Docx

1. Татварын цахим төлбөрийн баримтын системд цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлогыг зөрүүтэй буюу давхардуулж бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (К.Эрдэнэбаяр), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (А.Энхбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ